

Я.Цэрэндагва^{1✉}, Д.Цэвээндорж¹

¹ ШУА-ийн Археологийн хүрээлэн, Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө, ШУА-ийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

Их Баян уулын Бичигтийн амны бамбайт дайчны дүрслэл

Товчлол. Энэ өгүүлэлд Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутаг Их Баян уулын Бичигтийн амнаас шинээр илрүүлэн олсон хадны нэгэн гайхамшигт зураг болох бамбайгаар зэвсэглэсэн дайчны дүрслэлийг нийтэлж байна.

2019 оны хавар, зохиогчид Бичигтийн амны хадны зургийн гэрэл зураг авах, баримтжуулах, шинэ дурсгал олж илрүүлэх, дахин судлах ажлын хүрээнд нэгэн хошууны хаданд сийлсэн нум болон байлдааны сүхээр хоорондоо тулалдаж буй өгүүлэмжтэй зургийг илрүүлэн олсон юм. Хүрэл зэвсгийн үеийн хадны зурагт хоорондоо төрөл бүрийн зэвсгээр ойрын зайнаас тулалдаж буй байдлыг илтгэн харуулсан зохиомжит зураг олон байдаг хэдий ч хамгаалалтын гол зэвсэглэл болох бамбай барьсан дайчны дүрслэл тун ховор юм. Энэ зурагт дүрслэгдсэн дайчин эрийн барьсан бамбай нь буган чулуун хөшөөний зэр зэвсэг дотор олонтоо тааралдах таван талт дүрслэлтэй адилхан байна. Ийнхүү буган хөшөөнөө олон тоогоор дүрслэгдсэн байдаг бамбайн дүрслэл хадны зурагт анх удаа бодит байдлаар буюу дайчин эр гартаа барьж, нум сум харваж буй дайчны сумнаас хамгаалан буйгаар дүрслэгдсэнээр олдож байгаа нь судалгааны асар их ач холбогдолтой юм.

Манай орон болон хөрш зэргэлдээх орны бүс нутгийн буган хөшөөн дээр сийлэгдсэн, учир холбогдол, зориулалт нь маргаан дагуулж ирсэн дүрслэл бодитоор олдож хүрэл зэвсгийн үеийн судалгааны нэгэн маргаантай асуудалд цэг тавилаа хэмээн үзэж байна.

Бамбайт дайчны зургийн хадгалагдсан байдал, сийлсэн арга барил зэрэгт үндэслэн энэ зургийг хүрэл зэвсгийн хөгжингүй үед холбогдуулан авч үзлээ.

Түлхүүр үгс: Их Баян уул, Бичигтийн ам, хадны зураг, бамбай, буган хөшөө, хүрэл зэвсгийн үе

Ya.Tserendagva^{1✉}, D.Tseveendorj¹

¹Institute of Archaeology, Mongolian Academy of Sciences, Building-1, Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

Images of warriors with the shield from Bichigt Mount in Ikh Bayan Mountain

Summary. This article analyzes the image of the warrior with the shield – one of the most beautiful petroglyphs, discovered near Bichigt Mount in Ikh Bayan Mountain ridge, Bayanlig sum, Bayankhongor aimag. During the survey in 2019, when authors have being photographing, documenting and re-examining the petroglyphs of Bichigtiin am, they discovered an image of the fighting warriors, equipped by bows and axes. The carving was located on the rock, on the left side of the Mouth. The color of depiction is almost the same as rock background, that indicates the early age of this petroglyphs and makes possible relating it to Bronze Age. It is quite typical scene for the Bronze Age rock art – infighting with usage of different kinds of weapon. But there very few images with warrior, who uses the shield as the main security guard. The shield on this image is very similar to the pentahedral objects that can be found depicted on the deer stones and usually interpreted as the part of the ammunition. This is first time, when petroglyph, represented the warrior, holding the shield to protect himself from the arrows of other warriors. This discovery is unique and significant for understanding of types of ammunition and traditions of rock art in Bronze Age: we suppose that the picture finalized the discussion on meaning of pentahedral objects on the deer stones, found in Mongolia and neighboring territories.


Keywords: *Ikh Bayan Mountain, Bichigtiin am, petroglyph, shield, deer stone, bronze age*

Удиртгал

Баянхонгор аймгийн Бичигтийн аманд (зураг 1) Монголын хадны зургийн урлалын нэгэн хосгүй дурсгал хадгалагдан байдаг. Бичигтийн амны хадны зургийг анх 1972 онд археологич Н.Сэр-Оджав анх сурвалжлан үзэж, судлан 1987 онд “Баянлигийн хадны зураг” нэртэй бүтээлээ туурвисан юм. Энэ бүтээлд тус аман дахь 118 хаданд сийлэгдсэн 1000 гаруй дүр дүрслэлийг тодорхойлон холбогдох, гар зураг, гэрэл зургийн хамт нийтэлсэн билээ [Сэр-Оджав 1987].

1998, 2000 онд МОАХАЭ-ийн тусгай шинжилгээний анги тухайн дурсгал газарт очиж дахин судалгаа хийж, хадны зургуудын хуулгыг хийж, гэрэл зургаар баримтжуулснаар “Наскальные рисунки Баянлиг хада” хэмээх нэгэн сэдэвт бүтээл хэвлэгдсэн юм. Энэ бүтээлд 168 хаданд сийлэгдсэн 1500 орчим дүрслэлийг тодорхойлон нийтэлсэн байдаг [Деревянко, Петрин, Цэвээндорж, Мыльников 2008].

2019 онд энэ өгүүлийг туурвигчид Бичигтийн амны хадны зургийн судалгааг үргэлжлүүлэн хийх явцдаа урьд өмнө судалгаанд ороогүй олон



1-р зураг. Их Баян уулын Бичигтийн амны байршил



2-р зураг. Их Баян уулын Бичигтийн ам. Бамбайт дайчин дүрслэгдсэн газар

тооны зургийг шинээр илрүүлсний дотор бамбай барьсан дайчны зураг байв. Бичигтийн аманд судалгаа хийсэн судлаачид энэхүү зургийг анзааралгүй орхигдуулсан нь тодорхой учир шалтгаантай байсан бололтой. Энэхүү зураг нь хадны өнгөнөөсөө бараг ялгагдахгүй, дүрслэлийн тал хэсэг нь хагарч сүйдсэн байх тул хүний нүдэнд тэр бүр өртөхөөргүй байна. Мөн хурц нартай өдөр бол бараг л хаднаасаа ялгарч харагдахгүй байдалтай байгаа нь ийнхүү нууцлагдан үлдэх үндэслэл болсон ажээ.


Бамбайт дайчны дүрслэл

Бичигтийн амны том том зохиомжууд төвлөрсөн өвөлжөөнөөс урагш, амныхаа зүүн талын нэгэн хошууны бага зэргийн боосоодуу хадны налуу гадаргуу дээр нум сум, байлдааны сүхээр зэвсэглэсэн хоёр дайчин эр хоорондоо тулалдан байгааг битүү хонхойлон цоолборлон үлдээжээ. Зүүн талын дайчин солгой гартаа нарийн урт иштэй байлдааны сүх дээр өргөн далайж, нөгөө гартаа урт гонзгой таван талт бамбай халхлан барьж нум сумтны ойрын харвалтаас хамгаалан байгаа дүр зураг тодхон харагдана. Нум сумтны биеийн тал хэсгийн дүрслэлтэй хад хагарч ховхрон сүйдсэн хэдий ч цээжний талаас дээш хэсэг, нум сум бүтнээрээ хадгалагджээ. Бамбайг ажвал, таван талт хэлбэртэй, тагнай хээн чимэглэл бүхий, буган хөшөөн дээр дүрслэгдсэн байдагтай яг ижил аж. Бамбай барьсан дайчны хөл хэсгийг хажуугаас, харин биеийг эгц урдаас харсан байдлаар, бүснээс мөлгөр үзүүртэй богино муна маягийн зэвсэг зүүлгэн дүрсэлсэн онцлогтой. Энэхүү бамбайн хэмжээг хүний өндөртэй харьцуулах замаар тоймлон авч үзвэл 90-100 см урттай 40-45 см өргөнтэй гэж үзэж болохоор байна (зураг 3).


Зурагт дүрслэгдсэн бамбайн хийц хэлбэрийг тодорхойлон авч үзвэл, уртавтар таван талт хэлбэртэй, дээрээ зууван дугуй оройвчтой, босоо тагнайлдан хээлэн (тав) чимэглэжээ. Доод талаасаа 2 дахь тагнай хээний голд жижиг дугуй дүрс гаргасан нь бамбайн тольт бололтой. Урт хажуугийн дөрвөн булан дээш доош бага зэрэг илүү гарсан байдалтай харагдана.

Бамбайн үүсэл хөгжил, эртний урлагийн бүтээлд дүрслэгдсэн байдал

Бамбай бол эртний дайчдын зэр зэвсгийн олон төрөл зүйл дотроос ойрын болон холын тусгалт зэвсгээс хамгаалах үүрэг бүхий чухал ач холбогдолтой байлдааны хэрэгсэл юм. Бамбайг судлаачид үүрэг зориулалтаар нь нурууны, илдэт дайчны, жадат дайчны гэх зэргээр хэд хэдэн төрөл



1



2

3-р зураг. Бичигтийн амны бамбайт дайчны дүрслэл бүхий зураг


болгон хуваан авч үзсэн байдаг [Лукьяшко 2017:8]

Бамбайн гарал үүслийг багтай авч үзэх бодит баримт болох олдвор хэрэглэгдэхүүн тун багаар илэрч олдсон хэдий ч бидний таамаглаж байгаагаар нум сумыг сэдэж хийсэн, ойрын зайнаас илд, байлдааны сүх, зээтүү, жадаар тулалдахтай уялдан гарч ирсэн хамгаалалтын хэрэгсэл юм.

Мезолитын төгсгөл, неолитын эхэн үед саваа модны уян хатан чанарыг ашиглан холын тусгалтай нум сумыг ухаант хүн сэдэн бүтээсэн нь хүн төрөлхтний түүхэнд гарсан томоохон дэвшил, зэвсгийн хөгжилд гарсан нэг ёсны эргэлт, хувьсгал болсон билээ. Нум сумаар

ан агнахын зэрэгцээ харь овгууд хоорондоо дайтан тулалдахад хэрэглэх гол зэвсэг болсон нь тодорхой. Энэ үед холын тусгалт, үхлийн оноолт сумнаас өөрсдийгөө хамгаалах хэрэгсэл сэдэх зүй ёсны шаардлага урган гарсан нь мэдээж бөгөөд ойрын зайн тулааны үед хэрэглэх бугуйн хамгаалалтын хэрэгслээс улбаалан бамбайг сэдсэн бололтой. Чулуун зэвсгийн үед бамбайг гол төлөв модны холтос, мод, ширээр хийдэг байсан тул он цагийн уртыг даван бидний үе хүртэл хадгалагдан ирсэнгүй.

Эртний Египетийн зарим дүрс үсэг, Хоёр мөрний саваас олдсон эдлэлүүд дээр дүрслэгдсэн зарим дүрслэлийг судлаачид бамбайтай холбон авч үзсэн [Горелик 1993: 175-176] байдаг хэдий ч бамбай барьсан дайчдын дүрслэл бүхий ханын зураг, баримал, хадны зургууд дэлхийн олон газарт хадгалагдан үлджээ. Тэдгээрээс хамгийн эртнийх нь Эртний Египетийн түүхэнд холбогддог. НТӨ XX зуунд хамаарах Египетийн



4-р зураг. 1 – Месехтийн бунханаас гарсан модон сийлбэр [<http://iskusstvoed.ru/2016/03/14>], 2 – хүрэл толь [Эрдэнэчулуун, 2011], 3-Солохын булшнаас гарсан алтан сам [Лукьяшко, 2017, рис. 2], 4 – Гаймановын булсны сав [Лукьяшко, 2017, рис. 8], 5 – Куль Обагийн сав [Лукьяшко, 2017, рис. 3], 6 – Передериевын булшнаас гарсан титэм [Лукьяшко, 2017, рис. 5], 7 – Микены үеийн зэс чинжал [https://commons.wikimedia.org/dagger_inlaid_Mycenae-an_16_c_BC.NAMA.394_1080834].

Месехтийн (номарх) бунханаас бамбай жадаар зэвсэглэсэн олон тооны (40) дайчдын дүрслэл бүхий модон сийлбэр олдсон байна (зураг 4, 1). Тэдгээр дайчдын барьсан бамбай нь хэлбэрийн хувьд Бичигтийн амны бамбайтай тун төстэй. Ганц ялгагдах зүйл нь бамбайн чимэглэл болон дээд талын хоёр булан нь мөлгөр байгаа явдал юм.

НТӨ XVI зуунд холбогдох Микений үеийн хааны нэгэн бунханаас олдож Грекийн Афины Үндэсний Археологийн музейд хадгалагдаж буй зэс чинжаалд товойлгон дүрсэлсэн арслан агнаж буй жад, нумт анчдын зурагт бамбай дүрслэгдэн үлджээ. Энэ зохиомжид гурван арсланг жадаар намнаж буй таван анчныг дүрсэлсэн байна (зураг 4, 7). Анчдыг ар араасаа цувран гурван арсланг хөөж жадлан агнах гэж байхад нэг арслан гэнэт эргэж дайран эхний анчныг барьж унаган хөл доорооо гишгэлэн бусад руу нь үсрэн дайрч буй агшин нь зургийн үндсэн өгүүлэмж юм. Харин арсланд бариулж газарт дээш харан хэвтэж буй анчин бариулахаасаа өмнө бамбайгаа хаян, арслангийн ам руу жадаа зоож амжсан байна. Бусад гурван анчин жадаа шидэхээр далайж, нэг анчин нь нумаа хөвчлөн харваж алахад бэлэн зогсоо дүр зураг харагдах ба үлдсэн хоёр арслан тэднээс ум хумгүй зугтана. Энэ зурагт дүрслэгдсэн таван дайчдын жадаар зэвсэглэсэн дөрөв нь хоёр өөр төрлийн бамбай барьжээ. Сүүлийн болон урдаасаа хоёрдахь анчин хүний биеийг бүхэлд нь халхалсан голоороо нарийн, хоёр үзүүр цүлхэгэр өвөрмөц бамбай барьсан бол, арсланд бариулсан болон гурав дахь анчин таван талт урт бамбай барьжээ. Хэлбэрийн хувьд энэ бамбай нь Бичигтийн амны бамбайтай ижилхэн аж. Харин хэмжээ, чимэглэлийн хувьд өөр юм.

НТӨ I дэх мянган жилээс эхлэн Хоёр мөрний бүс нутгийн Ассир, Урартад дугариг хэлбэрийн бамбай дэлгэрч эхэлжээ. Ассирчууд дугариг бамбайгаа улаан өнгөөр буддаг байсан нь нэг ёсны нарны бэлгэдэл байсан [Горелик 1993:183] хэмээн үздэг.

Украин улсын Запорож мужийн Каменка хотоос холгүйхэн Днепр мөрний зүүн эрэгт орших Солохын булшнаас олдсон алтан саманд бамбай барьсан дайчдыг дүрсэлсэн байдаг. Энэ саманд богино илдээр зэвсэглэсэн хоёр явган дайчны нэг нь саран хэлбэрийн, нөгөөх нь дөрвөн булан нь мөлгөр зууван дөрвөлжин бамбайгаар халхлан охор жад барьж, төмөрлөг хуягтай зууван гонзгой бамбайгаар нуруу, мөрөө хамгаалалсан морьт дайчинтай хатгалдан байгааг дүрслэн харуулжээ [Манцевич 1949:75-80]. Энд гурван янзын бамбай дүрслэгдсэн байх ба морьтны бамбай нь нуруу халхлах бамбай, нөгөө хоёрынх нь гардан тулааны үед хэрэглэх хөнгөн бамбай ажээ (зураг 4, 3).

Нүүдэлчдийн ахуйн хэрэглээний сав суулга,

титмэн дээр ч бамбай дүрслэгдсэн байдаг. Тийм эдлэлийн тод жишээ бол Гаймановын булшнаас гарсан мөнгөн тагш, Куль-Обагийн алтан сав, Передериевын булшнаас олдсон титэм юм. Куль-Обагийн саван дээр дүрслэгдсэн охор жадаа тулан газарт суун ярилцаж байгаа хоёр дайчны нэг нь зүүн ташаандаа гонзгой хэлбэрийн, мөлгөр булантай бамбай зүүсэн байгаа нь тодорхой мэдэгддэг (зураг 4, 5). Энэ бамбай нь хэмжээний хувьд нэлээд том бөгөөд судлаачид явган цэргийн зориулалттай хэмээн үздэг [Лукьяшко 2017: 11, зураг 3].

Передериевын булшнаас гарсан титэм дээр илд барьсан хоёр дайчныг гайхам өгүүлэмжтэй дүрсэлсэн байдаг [Лукьяшко 2017: 13, зураг 5]. Хоёр дайчны баруун талынх нь газарт сөгдөн сууж охор илдээ хуйнаасаа сугалахаар завдан байх ба зүүн талын дайчин эр баруун гартаа илдээ сугалан барьж, зүүн гартаа барьсан тэгш өнцөгт хэлбэрийн ханан хээ бүхий бамбайгаа суугаа дайчны толгойн харалдаа барьжээ. Хоёр хараа нэгэн зүгт чиглэсэн бөгөөд царайны төрхөөс нь эсрэг талын дайчидтай тулалдахад бэлдэн байгаа нь илхэн мэдэгдэнэ (зураг 4, 6). Энэ бамбайтай төстэй тэгш өнцөгт хэлбэрийн бамбай Гаймановын булшнаас гарсан хоёр чихтэй мөнгөн тагш (Зураг 4, 4) дээр мөн дүрслэгдсэн байдаг [Лукьяшко 2017: 14, зураг 8].

Дундговь аймгийн Хулд сумаас олдож, хувь хүний цуглуулгад байсан нэгэн хүрэл толинд хоорондоо тулалдан буй хоёр морьт дайчны дүрс байх ба нэг нь нум сумаар, нөгөө нь байлдааны зээтүүгээр зэвсэглэжээ [Эрдэнэчулуун 2011:265]. Зээтүү барьсан дайчин тэгш өнцөгт хэлбэрийн, туг судал зураас чимэглэлтэй бамбай барьсан нь тодхон харагддаг. Энэ бол бамбай дүрсэлсэн ховор олдворын нэг юм (зураг 4, 2).

Хятадын Жоу улсын түүхэнд холбогдох нэгэн зурагт ч Таван талт, гонзгой урт бамбай дүрслэгдэн үлдсэнийг судлаачид буган хөшөөний бамбайтай адилтган олонтоо эш татан нийтэлсэн байдаг [Новгородова 1989].

Бамбайн биет олдворууд

Евроазийн нүүдэлчдийн хэрэглэж байсан бамбай тэдний булш оршуулгаас цөөвтөр тоогоор олджээ. Энэ нь нүүдэлчид бамбайг мод, арьс шир гэсэн органик материалаар хийж байсантай холбоотой бөгөөд он цагийн уртыг даван хадгалагдан хоцрох нь бараг үгүй юм. Бичгийн сурвалжид скиф, сарматын нүүдэлчдийн бамбайн талаар бичигдэн үлдсэн нь бий. Грекийн түүхч Геродот (НТӨ VI зуун) скифүүд сүлжмэл модон болон арьсан бамбай хэрэглэдэг [Геродот 1972] тухай бичсэн байдаг. Эртний Ромын газарзүйч Страбон (НТӨ II-НТ II зуун) роксоланы овгийнхон модны мөчрөөр сүлжин хийж, ширээр бүрсэн

бамбай хэрэглэдэг байсан тухай бичиж байв [Страбон 1964].

Бамбай эртний булш оршуулгаас биетээр олдсоны эртнийх нь түрүү төмрийн үед холбогддог. Уулын Алтай, Монгол Алтайн төмрийн түрүү үеийн булшнаас бамбай биетээр олноод байна. Түрүү төмрийн үеийн булшнаас саваа модыг нимгэн арьс ширэнд сүвлэн хийсэн бамбай, цул модон гэсэн үндсэн төрлийн бамбай илэрч олддог.

Шир сүвлэмэл бамбайны хувьд анхлан Пазырыкийн булшнаас гарсан юм. Уулын Алтайн Пазырыкийн хотгорт урдаас хойд зүг эгнүүлэн цогцлоосон таван том чулуун дараастай булшны төв дунд орших хамгийн томыг (47 м голчтой, 2,2 м өндөртэй) 1929 онд ЗХУ-ын археологич М.П.Грязновын удирдсан шинжилгээний анги малтан шинжилж археологийн судалгааны түүхэнд урьд хожид тохиолдож байгаагүй гайхамшигт олдворуудыг нээн илрүүлсний дотор нарийн саваа моднуудыг нимгэн арьс ширэнд зэрэгцүүлэн шургуулан сүвлэж хийсэн бамбайнууд багтдаг. Энэ булшнаас нийтдээ гурван ширхэг бамбай олдсон нь бүгд морины эмээлд уяатай байжээ. Тэдгээр бамбайг хийхдээ тус бүрд нь 35 ширхэг нарийн саваа модыг эгнүүлэн, урьдчилан бэлдсэн нимгэн ширээ саваа мод орохоор сэтлэн зүсэж модоо гүйлгэн сүвлэж холбон хөдөлгөөнгүй бэхэлсэн байжээ [Грязнов 1950:63]. Урьдчилан жирийлгэн зүссэн хэсгээр саваа модоо шургуулахдаа бамбайн гадар дээр хээ болон тодорч харагдахаар сэтгэн хийж байсан нь пазырыкчуудын уран сайхны сэтгэлгээний царыг илтгэн харуулдаг. Уулын Алтайн пазырыкийн 1-р булшнаас гарсан гурван бамбайн хоёр нь давхар сүйхэлжин хээтэй, нэг нь таван эгнээ уулан хээтэй ажээ [Грязнов 1950: 73 - зураг 28; 96 Хүснэгт X]. Уулан хээ, давхар сүйхэлжин хээтэй бамбайн дүрслэл буган чулуун дээр олон дүрслэгдсэн байдгаас үзэхэд буган хөшөөний бамбайн дүрслэлийн биет хэрэглэгдэхүүн нь яах аргагүй энэхүү пазырыкийн булшнаас гарсан эдлэл мөн ажээ.

Сүвлэмэл саваа модон бамбайн хийсэн арга барилын талаар Руденкогийн тодорхойлсныг авч үзвэл, юун түрүүн бамбайн гол хэсэг болох саваа модыг хатуулаг сайтай хар мод, хуш, жодоогоор бэлтгэдэг байсан байна. Хэлбэр хэмжээний хувьд нум сумны мөстэй тун төстэй.

С.И.Руденкогийн удирдсан шинжилгээний анги 1947-1948 онд Пазырыкийн 2-4-р булшийг малтан судлахад 2-р булшнаас хоёр, 3-р булшнаас гурван бамбай гарчээ [Руденко 1950:20]. Энд сонирхуулахад, пазырыкийн 2-р булшийг малтан судалсны дараа С.И.Руденко бамбайн үүрэг зориулалтын талаар нэгэн таамаг дэвшүүлсэн байдаг. Тэрээр бичихдээ, “би 1-р

булшны малтлагын урьдчилсан мэдээлэлдээ бамбайны хэмжээ хэдий жижиг (27-37 см) ч гэсэн хамгаалалтын зэвсэг гэдэг нь тодорхой гээд Солохын булшнаас олсон алтан самны дүрслэл дээрх дайтаж буй дайчдын бамбайтай харьцуулан авч үзсэн. Харин энэ төрлийн бамбайг арьсан ууттай хоол хүнсний хамт морины эмээлээс уяснаар олсон нь өмнөх дүгнэлтээсээ татгалзахад хүргэж байна. Энэхүү бамбай нь арьсан ууттай хоол хүнсний зүйлийг морины биед хүрэхээс хамгаалах зориулалттай эдлэл хэмээн бодож байна” гэж пазырыкийн булшнаас гарсан бамбайн зориулалтын талаар өөрийн өмнөх саналаа үгүйсгэн шинэ санаа дэвшүүлсэн аж [Руденко 1948:17]. Түүний энэ санаа сонирхолтой хэдий ч цаашдын судалгааны дүнд энэ төрлийн эдлэл зэвсэглэлийн зориулалттай бамбай гэдэг нь улам тодорхой болсон билээ.

Уулын Алтайн (АБНУ) Урсул голын хөндийд орших Туэктийн 1-р булшнаас ширэнд суулгасан таван бамбай илэрсний зэрэгцээ цул модон бамбай анхлан олджээ [Руденко 1960:122, 123; зураг 73-74]. Мөн түүнчлэн Алтайн Бүгд Найрамдах улсын Ак-Алахаас гурван бамбай [Полосьямак 1994:34-35; 2001:91], Уландрыкаас гурван бамбай [Кубарев 1987:74-75, 158-159], Бертекээс [Древные культуры..., 1994:93; Полосьямак, 1992:58-59] тус бүр нэг бамбай олдож байв.

Уландрыкийн бамбайнуудыг авч үзвэл хадгалалт муу хэдий ч хэмжээ, хийцийг бүрэн харж болохоор ажээ. Уландрыкийн гурван бамбайны хоёр нь ширэнд суулгасан саваа модоор хийсэн бол Ташаантаас олдсон нь цул модон бамбай [Кубарев 1987:75, рис 26,1] юм.

В.Д.Кубаревын тодорхойлсноор, Уландрык-I-ийн 5-р булшнаас гарсан нэг бамбай нь 82x36 см хэмжээтэй, тэгш өнцөгт хэлбэртэй. 40-45 ширхэг, 0,5-0,6 см голчтой нарийн саваа модыг ширэнд сүвлэн хийсэн байжээ. Уг бамбайг оршуулсан хүнийхээ доор дэвссэн байсан нь ихээхэн сонирхолтой юм. Энэ төрлийн өөр нэг бамбайн үлдэгдэл Уландрык-IV-ийн 2-р булшаас гарсан нь ихээхэн эвдэрч гэмтсэн байсан ба хэмжээний хувьд нөгөө бамбайнаас жижиг, морины эмээлнээс уяатай байсан байна. Ташант-I-ийн 1-р булшнаас гарсан цул модон бамбай мөн л морины эмээлийн ойроос олдсон ба 44x35 см хэмжээтэй, дотор тал нь цулгуй, гадна талд нь 1 см орчим өргөнтэйгээр саваа мод мэт харагдахаар завсаргүй сийлбэр хийсэн байжээ [Кубарев 1987:75, зураг 26,1]. В.Д.Кубарев эхний бамбайг бодит бамбай, харин нөгөө хоёр бамбайг оршуулгад зориулж хийсэн дуураймал загвар хэмээн үзсэн байна.

Уулын Алтайн Укок (Үхэг)-ын бэгэлцгийн Ак-Алах голын хөндийд малтсан төмрийн түрүү үед холбогдох дурсгалаас нийтдээ гурван бамбай

олджээ. Тэдгээр нь бүгд цул модон, жижиг хэмжээтэй ажээ. Нэг нь Ташаантаас олдсон бамбайтай адил саваа бамбайг бэлгэдсэн 28 босоо нарийн сийлбэртэй, 27,5x38 см хэмжээтэй. Харин нөгөө хоёрын гадна талд уулзмал тагнай хээ болон ханан хээг ухаж сийлснээс гадна улаан зосон будгийн үлдэгдэл хадгалагдаастай байсан байна. Тэдгээрийн хэмжээ нь 28,5x37,5, 24,5x35,5 см [Полосьямак 2001:54]. Бүх бамбайн төв дунд жижиг нүх гаргасныг бариул оосор бэхлэх үүрэг зориулалттай хэмээн Н.В.Полосьямак үзсэн байна.

Монгол Алтайд Пазырык булшийг малтан судлах ажил 1990-ээд оны дундуураас эхэлснээс хойш олон арван дурсгалыг малтан судалсан билээ. Тэдгээрийн хоёроос гурван бамбай гарсан байна. Энэ нь Олон гүүрийн гол (Олон нуурын гол Я.Ц)-10-ын 1 болон [Цэвээндорж нар. 2016:32, 122-123, 185], Сыргаль 3-ын 1-р булшууд [Төрбат нар. 2011:127] юм.

Хожим Д.Батсүх, Н.Эрдэнэ-Очир нар Монгол Алтайгаас олдсон тэдгээр гурван бамбайг төрөлжүүлэн ангилах оролдлого хийсэн байна. Бамбайнуудыг хийсэн материалаар нь мод гэсэн үндсэн бүлэгт хамааруулж, дотор нь цул модон төрөлд хуваан, хэлбэрээр нь тэгш өнцөгт дөрвөлжин, дөрвөлжин гэсэн хоёр хэлбэрт ангилан авч үзжээ [Батсүх, Эрдэнэ-Очир 2017:151].

Олон гүүрийн 10-р оршуулгын газрын 1-р булшнаас гарсан бамбайг морины эмээлийн харалдаа бунхны тагны дээд ирмэгээс олдсныг, эмээлээс зүүсэн байсан гэж үзжээ. Судлаачид, “тэгш өнцөгт бамбайн дөрвөн буланг засжээ. Эдлэлийн гадна талыг ташуу шугамаар хоёр хуваагаад тал болгонд олон зэрэгцээ ховил сийлэн хээлсэн байв. Бамбайн голд жижиг нүх гаргасан нь бариул бэхлэх зориулалттай юм” хэмээн анхлан тодорхойлж байв [Цэвээндорж, Молодин, Парцингер, 2016:32]. Сүүлд Д.Батсүх, Н.Эрдэнэ-Очир нар уг бамбайг тэгш өнцөгт дөрвөлжин бамбайн хэлбэрт оруулан, тодорхойлон голд гаргасан нүхийг бариул бэхлэх зориулалттай бололтой хэмээсэн байна [Батсүх, Эрдэнэ-Очир 2017:151]. Энэхүү бамбай нь 32 x 18 x 0,6 см хэмжээтэй ажээ.

Сыргалийн 3-р дурсгалын 1-р булшнаас гарсан хоёр бамбай хоёул цул модон бамбай аж. Тэдгээрийн нэг нь тэгш өнцөгт дөрвөлжин нөгөө нь дөрвөлжин бамбай ажээ.

Эхний бамбай нь 25x15x1 см хэмжээтэй [Батсүх, Эрдэнэ-Очир 2017:151]. Гадна талыг дөрөв хошуулдан хувааж, дээд доод хоёр хошууг ташуу гурив гарган ховилдон сийлж хээлсэн байна. Бамбайн төв хэсэг мөн жижиг дөрвөлжин нүхтэй.

Хоёр дахь бамбай нь дөрвөлжин хэлбэртэй, 17x16x1 см хэмжээтэй. Гадна талыг дөрөв

хошуулдан тагнайлдан сийлж тус бүрийг хээлсэн байна. Энэ бамбайн нэг онцлог нь төв дунд төдийгүй дөрвөн буланд нүх гаргасан явдал юм.

Бамбайн биет олдворууд Зүүн Европоос олддог хэдий ч хэлбэр хэмжээний хувьд Алтайн бүс нутгаас олдсон эдлэлүүдээс эрс ялгардаг. Днестр мөрний орчмын Глиное тосгоны дэргэдэх түрүү төмрийн үеийн дөрвөн булшнаас зууван хэлбэрийн байж болохоор өмхөрч ялзарсан модон бамбайны үлдэгдэл олдсон байна [Синика, Тельнов 2015:345].

Дээр дурдсан бүхнээс үзэхэд төмрийн түрүү үеийн Алтайн бүс нутагт тархсан соёлд бамбай нь үндсэн хоёр төрөл байсан нь мэдэгдэнэ. Энэ нь шир сүвлэмэл саваа модон бамбай болон цул модон бамбай юм. Одоогийн байдлаар манай хөрш зэргэлдээх бүс нутгуудаас цул модон бамбай 7 олдод байна. Энэ нь Туэктын 1-р булш, Ак-Алах-1-н 1-р булш (3 ш), Ташаант-1-н 1-р булш, Бертек, Берелийн булшнаас гарсан бамбайнууд байна. Зарим судлаачид тэдгээр цул модон бамбайнуудыг оршуулгын зан үйлд зориулан, шир сүвлэмэл бамбайг дуурайлган хийсэн загвар хэмээн үздэг [Кубарев 1987:75; Руденко, 1960:123] бол зарим нь явган болон морин цэргийн хэрэглээнд байсан хамгаалалтын бодит зэр зэвсэг [Горелик 1987:126, Полосьмак, 1992:58; Кочеев, 1998: 78] хэмээн үздэг ажээ.

Бамбайн чимэглэл болон тольт

Бичигтийн амны дайчны барьсан бамбай нь судлаачдын нэрлэж заншсанаар тагнай хэлбэрийн хээтэй, төв хэсэгтээ дугуй тольттой дүрслэгджээ.

Бамбайг хээлэн чимэглэх, төмөр товруу бэхлэн гоёх, төмөр хээг бэхлэн хадах явдал түгээмэл байжээ. Мөн саваа сүлжмэл бамбайнуудыг холбон бэхлэсэн нимгэн шир, сураар нь хээ гарган чимэглэж байсныг дээр дурдсан пазырыкийн булшнаас гарсан бамбайнууд гэрчилдэг. Цул модон бамбайнуудын гадна талыг ховил гарган сийлэн ухаж хээлэн чимэглэдэг байсныг Олон гүүрийн гол, Сыргалын бамбайнаас харж болохоор байна. Уулын Алтай, Монголоос олдсон модон бамбайнуудын ихэнхийн төв дунд жижиг нүх гаргасан байх ба үүнийг гарт барих оосорт зориулагдсан хэмээн ихэнх судлаач үзсэн боловч чухам хэрхэн оосроо бөхөлж байсан талаар тухайлан дурдсан зүйл үгүй байна. Зарим тохиолдолд гол нүхний хажууд өөр нэг жижиг нүх гаргасан тохиолдол цөөнгүй байгаа нь энэ хоёр нүхээр оосроо шургуулан гогцоолдон барьдаг байсан байж болох юм. Гэвч ганц нүхтэй бамбай олон байна. Миний бодлоор энэ жижиг нүх нь бамбайн голд гадна талд бэхэлсэн тольтод уясан оосрыг дотор тал руу гаргах үүрэгтэй байжээ. Өөрөөр хэлбэл тольтыг гадна талд бэхлэн, түүний

дотор байх сэнжинд бэхэлсэн оосор уяаг энэ нүхээр шургуулан барьдаг байжээ.

Хожуу үеийн бамбайн чухал хэсгийн нэг бол тольт юм. Тольт нь дугуй хэлбэрийн хүрээтэй хөөмөл метал, том хэмжээний товруу байдаг. Ихэвчлэн тал бөмбөлөг, шовх хэлбэртэй. Тольт нь бамбайн бат бөх байдлыг хангахаас гадна дайчны гарын бугуйг хамгаалах үүрэгтэй байжээ. Тольтын эсрэг талд голчлон бамбайн бариул байдаг. Мөн зарим тохиолдолд бамбайн чимэглэл болдог байв. Тольтыг хээлэн чимэглэсэн байх нь түгээмэл. Мөн түүнчлэн тольтыг шовх олон тооны өргөстэй хийдэг байсан нь илд, жад, сумны эрчийг хариулах хамгаалалтын үүрэгтэйгээс гадна бамбайг цохих зэвсэг болгон ашиглахад чухал үүрэгтэй байв. Тольттой бамбай Европын эртний Кельт, Германчуудын дунд түгээмэл тархсан байжээ. Эртний Ромын армийн зэвсэглэлд ч тольт бүхий төрөл бүрийн хэлбэрийн бамбай хэрэглэгдэж байв. Тольттой уялдуулан хожуу үеийн бамбайн чимэглэлийн талаар товч өгүүлэхэд бамбайг төрөл бүрийн нимгэн металл ялтсаар хээлэн чимэглэдэг байжээ. Энэ нь мөн л хамгаалах үүрэгтэйгээс гадна чимэглэл болдог байв. Бамбайг амьтны дүрс бүхий янз бүрийн товруугаар чимэглэх явдал түгээмэл тохиолдоно. Крымийн хойгийн Куль Обагаас олдсон бугын дүрслэлтэй товруу үүний тод жишээ болно.

Бичигтийн амны хадны зураг дахь бамбайн тагнайлдсан олон эгнээ дүрслэл бол бамбайн эх бие болох саваа модыг хөдөлгөөнгүй бэхлэх үүрэгтэй, саваа модыг эгнүүлэн шургуулах нимгэн шир бөгөөд саваа модыг шургуулсны дараа нэг ёсны хээн чимэглэл мэт харагдахаар сэтгэж хийдэг байжээ. Энэ нь пазырыкийн булшнаас олдсон зүймэл саваа бамбайнуудаас тодорхой мэдэгдэнэ. Харин голд нь байх дугуй дүрслэл нь төмөрлөг тольт бололтой. Буган хөшөөн дээрх бамбайн төв болон дээд талд дүрслэгдсэн байдаг дугуй, зууван, дөрвөлжин, босоо дөрвөлжин дүрслэлүүдийг тольт хэмээн В.В.Волков, Э.А.Новгородова нар анхлан тайлбарласныг энэ ташрамд цохон дурдах нь зүйтэй [Волков 1981:235; Новгородова, 1989:197].

Буган хөшөөний бамбайн дүрслэл

Монгол орноор төвлөрөн тархсан археологийн гайхамшигт дурсгал болох буган хөшөөн дээр олон төрлийн зэр зэвсэг дүрслэсэн байдгийн нэг нь бамбайн дүрслэл юм. Буган хөшөөний судалгааны эхэн үед энэхүү дүрслэлийн утга санааг судлаачид таамаглан оромж сууц (байшин) [Маннай-Оол 1970:27], хүний хэнхдэг өвчүүний хавирга бүхий дүрслэл [Вайнштейн 1974:30; Савинов, Членова, 1979: 75] хэмээн үзэж байв. Харин бамбай гэдэг саналыг анх 1974 онд археологич Д.Цэвээндорж

дэвшүүлэн тавьж байсан [Цэвээндорж 1974:18] бөгөөд энэ саналаа бамбайн талаар тусгайлан судалсан өгүүлэлдээ улам лавшруулан авч үзсэн байна. Түүний дараагаар ЗХУ-ын (хуучнаар) археологич М.А.Девлет, Э.А.Новгородова [Новгородова 1975] нар түүнтэй адилхан санал гаргажээ.

Д.Цэвээндорж тухайн үеийн судалгааны түвшинд Монгол, хөрш зэргэлдээх нутаг орноос илэрч мэдэгдээд байсан 32 тооны “сараалжтай, таван өнцөгт хачин дүрс”-ийг харьцуулан судлаж, зэр зэвсгийн хамт дүрсэлсэн байдлаас үндэслэж зэр зэвсгийн төрөлд оруулан бамбайн дүрслэл гэж үзэх саналаа улам лавшруулан тайлбарласан юм [Цэвээндорж 1976:54]. Мөн тэрээр буган хөшөөнөө “таван өнцөгт” бамбайг нэн эртний хэлбэрээр дүрсэлсэн гэж үзсэн байна. Тэрээр өөрийн дэвшүүлсэн саналаа Уулын Алтайн мөнх цэвдэгт булшнаас биетээр илэрч олдсон бамбайнуудтай харьцуулан авч үзжээ.

М.А.Девлет, Италийн судлаач Э.Анати нар 1975 онд хэвлэгдсэн номондоо нийтэлсэн, Альпийн нурууны Камоникийн хөндийн (Валь Камоник) хадны зурагт дүрслэгдсэн бамбайн гурван дүрслэл, Тува улсын орон нутгийг судлах музейд Самагалтайгаас авч ирэн хадгалсан хоёр талдаа таван талт бамбайн зураг, араатан амьтдын зурагт тулгуурлан буган хөшөөн дээр дүрслэгдсэн “таван талт” нууцлагдмал дүрсийг бамбай хэмээн тодорхойлжээ [Девлет 1976:233].

Хожим судлаачид буган хөшөөний энэхүү дүрслэлийг бамбай гэдэг дээр нэгэн дуугаар санал нэгдсэн [Волков 1981:90; Эрдэнэбаатар, 2002:72-74] боловч зарим судлаач өөр таамаг дэвшүүлсээр байжээ. Тухайлбал, Д.Г.Савинов хүний сүнс байрлаж байх орон байр, сав байж болох юм [Савинов 1994: 149] гэсэн таамаглал дэвшүүлж байв. Ж.Баярсайхан бөөгийн хэнгэргийн бариул болон ташуур дээр дүрслэгдсэн байдаг тагнай хээн утга бэлгэдэлтэй холбон мөн л нуруу хавирганы дүрс хэмээн үзсэн [Bayarsaikhan 2005:41-46] хэдий ч хожим энэ үзэл санаанаасаа татгалзан бамбай [Баярсайхан 2017:171] гэж үздэг саналтай нэгдсэн байна.

Монгол улсын нутаг дэвсгэрээс өнөөгийн судалгааны түвшинд илэрч олдож бүртгэгдээд буй 1241 [Монгол ба бүс нутгийн..., Боть 1. УБ,2021; Монгол ба бүс нутгийн..., Боть 2. УБ.,2021] буган хөшөөний 284-т 285 тооны таван талт, тагнай хээтэй бамбай сийлэгджээ. Аймаг тус бүрийн дурсгалаар авч үзвэл Архангай аймагт бүртгэгдсэн 257 буган хөшөөний 97-д, Баян-Өлгий аймгийн 58 буган хөшөөний 3-т, Баянхонгор аймгийн 103 буган хөшөөний 22-т, Булган аймгийн 68 буган хөшөөний 24-т, Говь-Алтай аймгийн 39 буган хөшөөний 1-т, Дархан-Уул аймгийн 3 буган



5-р зураг. Хадны зураг дахь бамбайн дүрслэл (1-5, 7, 8) ба бамбай дүрсэлсэн хавтан чулууд (6, 9, 10)

хөшөөний 1-т, Завхан аймгийн 84 буган хөшөөний 23-т, Өвөрхангай аймгийн 58 буган хөшөөний 8-д, Сэлэнгэ аймгийн 10 буган хөшөөний 5-д, Төв аймгийн 14 буган хөшөөний 4-т, Увс аймгийн 54 буга хөшөөний 6-д, Улаанбаатар хот орчмоос олдсон 2 буган хөшөөний 1-т, Ховд аймгийн 155 буган хөшөөний 21-т, Хөвсгөл аймгийн 227 буган хөшөөний 67-д, Хэнтий аймгийн 14 буган хөшөөний 3-т тус тус бамбай дүрслэгдсэн байдаг байна.

Буган хөшөөн дээр дүрслэгдсэн бамбайнуудаас үзэхэд гадна хэлбэрийн хувьд дөрвөлжин, таван талт, зургаан талт [Төрбат нар. 2021:176] гэсэн үндсэн гурван төрөл байх ажээ. Дээрх буган хөшөөн дээрх таван талт баймбайнуудыг тагнай хээ, хээн чимэглэлээр нь дараах үндсэн хэв шинжид хуваан үзэж болмоор байна.

1. Дан тагнай хээтэй; 2. Тагнай хээ, голоороо босоо зураас бүхий; 3. Тагнай хээ, тал босоо зураас бүхий; 4. Тагнай хээ, голдоо дугуй тольттой; 5. Тагнай хээ, иштэй тольт бүхий; 6. Босоо зэрэгцээ хээ бүхий; 7. Уулан хээ бүхий; 8. Ташуу 2-3 тольттой; 9. Тасалданги тагнай хээтэй; 10. Сүйхэлжин хээтэй; 11. Сүлжмэл хээтэй; 12. Хөндлөн эгнээ зураастай; 13. Хүрээгүй тагнай хээ бүхий.

Дээрх ангилал бол зөвхөн харагдах байдал, бамбайн гадна талд дүрсэлсэн “хээ”-ний хэлбэр янзаас улбаалан гаргасан явдал бөгөөд дотроо мөн олон хуваагдах шинжтэй байгааг цохон дурдсу. Тухайлбал тольтын хувьд холбоотой 2-3, босоо дөрвөлжин хэлбэртэй ч тааралдана. Мөн хүрээтэй тольг ч бий.

Хадны зургийн бүтээл дэх бамбайн дүрслэл

Бамбай дүрсэлсэн хадны зургуудаас анхлан судалгааны хүрээнд мэдээлэгдсэн дурсгал бол дээр өгүүлсэн Италийн Камоникийн бүтээл юм. Энэ хадны зургийн гайхамшигт дурсгалд олон үеийн хэдэн зуун мянган дүрслэл дүрслэгдсэн байдаг бөгөөд бамбайн олон дүрслэл бий (Зураг 5, 3, 4). Тэдгээр дүрслэлийг харахад голчлон том, дунд зэргийн хэмжээтэй, дөрвөлжин хэлбэртэй байна [Anati 1975; De Marinis, Fossati 2012:27].

Монголын хадны зургийн дурсгал дотор бамбай дүрсэлсэн зурагт газар урьд өмнө олдож байв. Археологич Н.Сэр-Оджав, Т.Санжмятав нар 1988 онд Өмнөговь аймгийн Номгон сумын нутагт хадны зураг, бичээсний хайгуул судалгаа хийх явцдаа Уртын голын эргийн нэгэн хадан цохионоос олон тооны сонирхолтой зураг илрүүлсний дотор бамбай барьсан дайчны зураг байна [Санжмятав 1995:44]. Энэ зурагт Бичигтийн амныхтай нэгэн адилаар байлдааны сүх (зээтүү) барьсан дайчин эр, жадаар зэвсэглэсэн хүнтэй тулалдан байгаа байдал дүрслэгджээ. Уртын голын бамбайны хувьд дөрвөлжин хэлбэртэй байх ба цулгуй, ямар нэгэн хээ үгүй юм. Хэмжээний хувьд жижгэвтэр харагдана (Зураг 5, 2). Энэ дурсгалын бамбайт дайчны зургийг геологич Д.Гарамжав бас нийтэлж байв [Гарамжав 2011:24]

Бичигтийн амны өөр нэгэн хаданд ч мөн бамбай барьсан хүний зураг бий. Бичигтийн амны өвөлжөөний ойролцоох нэгэн хавтгай хадна дээрээс доош эгнүүлэн дүрсэлсэн таван үхрийн зураг байх ба тэдгээр үхрүүдийн баруун доод талд шовгор хэлбэртэй малгай өмсөн, нум сум, дөрвөлжин бамбай барьсан хоёр хүнийг дүрсэлсэн байдаг [Сэр-Оджав 1987, Деревянко нар. 2008:169, зураг 130]. Энэ зурагт дүрслэгдсэн дайчны хувьд дөрвөлжин хэлбэрийн бамбайг зүүн гартаа барьж, баруун гартаа байлдааны сүх, зээтүү дээш өргөн барьснаар дүрслэгдсэн ажээ (зураг 5, 1). Хүний өндрийн хэмжээтэй харьцуулахад энэ бамбай нэлээд том хэмжээтэй болох нь мэдэгдэнэ.

Архангай аймгийн Батцэнгэл сумын нутаг Хөрөөгийн үзүүрийн хаданд дүрслэгдсэн таван талт бамбайн зураг байгааг археологич Ж.Гантулга нар судлан нийтэлсэн юм [Гантулга, Ерөөл-Эрдэнэ, Магай 2018: 133, зураг 394].

Уг зурагт таван талт, тагнай хээтэй бамбай дүрсэлсэн нь нэлээд бүдгэрсэн байжээ (Зураг 5, 7).

Уг дүрслэлээс харахад, бамбайн доод хэсэг цулгуй ба дээрээс гол хэсгийн дооно хүртэл зургаа тагнайлдан хээлсэн байх ба үзүүрүүдийг хажуу хүрээнд хүргэлгүй зай гарган цоолборлосон байна. Судлаачид “Хөрөөгийн үзүүрийн хадны зургийн дурсгалаас буган хөшөөн дээрх бамбайн дүрслэлтэй тун адил таван талт хэлбэртэй, тагнай хээ бүхий дүрслэл олдсон нь уг хоёр дурсгалын он цагийг тогтоох чухал хэрэглэгдэхүүн болж байна” хэмээн онцлон тэмдэглэсэн байна.

Казахстаны нутаг Хар Эрчис мөрний баруун эрэг Сагыраас муна барин тулалдаж буй дайчдын нуруунд дүрслэгдсэн босоо зураасыг З.С.Самашев бамбай хэмээн тодорхойлсон байдаг. Энэхүү босоо нарийн дүрснээс хөндлөн богино зураасаар хүний биетэй холбосон мэт харагддаг ба үүнийг оосор хэмээн үзэж, бамбайг хажуугаас дүрсэлсэн тул хэлбэрийг тодорхойлох боломжгүй юм гэжээ [Самашев 1992: 169].

Сагырын хүний нуруундаа үүрсэн дүрстэй ижил дүрслэл Енисей мөрний Саяны хавцлын Мозага-Хомужакаас мөн олдсныг М.А.Девлет, Е.Г.Девлет нар тодорхойлсон ч илтгэлдээ зургийг нь хавсаргаагүй байна. Тэдний тодорхойлолтоос үзэхэд янгирын араас нум сумаа татан харвах гэж буй хүний нуруунд урт гонзгой хэрэгсэл үүрүүлэн биетэй нь гурван нарийн зураасаар холбон зурсан байжээ [Девлет, Девлет 2007:96].

ОХУ-ын Тува улсын Самгалтайгаас олдсон хоёр хавтгай чулуун дээр таван талт, тагнай хээтэй бамбайг урласан байдаг [Девлет 1976: 233]. Тэдгээрийн нэгийг тойруулан эвэрт морь, янгир, бодон гахай, нумт морьтныг дүрсэлсэн нь сонирхолтой. Уг зурагт байгаа нумт морьтон нь бамбайн гол хэсэг рүү нумаа татан сумаа харваж байгаа өгүүлэмжтэй зурагджээ (Зураг 5, 5).

Өөр нэг бамбайн зураг Тува улсын Бегирын голоос олдсон нь хийцийн хувьд болхидуу сийлсэн таван талт, тагнай хээ бүхий ажээ (Зураг 5, 8) [Килуновская 1999].

Хадны зураг, буган хөшөөнөөс гадна хавтгай чулуугаар бамбай хийх, хавтан чулууны тэг хүрээнд тааруулан урлах заншил Төв Азийн нүүдэлчдийн дунд байжээ. БНХАУ-ын Шинжааны Бархөлийн хиргисүүр-буган хөшөөний цогцолбор дурсгалаас таван талт тагнай хээтэй болон цулгуй таван талт чулуун бамбайнууд (Зураг 5, 6, 10) илэрч олдсон байна [Guo et al. 2016:985-997. зураг 20, 1-4].

Тувагийн Аржан-2 дурсгалыг малтан судлахад голоороо босоо зураас бүхий таван талт тагнай хээ сийлсэн хавтан чулуу (Зураг 5, 9) гарчээ [Чугунов 2008:54].

Хэлэлцүүлэг

Бидний авч үзэж буй бамбайн дүрслэлийг тайлбарлаж ирсэн эрдэмтдийн судалгаанаас харахад юун түрүүн анхаарал татдаг нэг асуудал бол уг дүрслэлийн үүрэг зориулалт, ямар зүйл болох тухай асуудал билээ. Анхлан буган хөшөөн дээр дүрсэлсэн энэ төрлийн дүрслэлийг судлаачид өөр өөрийн өнцгөөс харж янз бүрээр нэрлэж ирсэн хэдий ч хүрэл зэвсгийн үеийн дайчдын олон төрлийн зэр зэвсгийн нэг болох бамбай болох нь маргаангүй юм.

Монгол улсын нутаг дэвсгэрт төвлөрөн цогцлоосон буган чулуун хөшөө хэмээх хүрэл зэвсгийн үеийн гайхамшигт, сүрлэг дурсгалд ихэвчлэн дүрслэгдсэн бамбайн олон төрлийн нэг болох таван талт, тагнай хээн чимэглэл бүхий бамбай Бичигтийн амны хадны зурагт тод томруун дүрслэгдсэн байгаа явдал нь энэхүү дүрслэлийн үүрэг зориулалт хийгээд, гарал үүслийн асуудлыг нөхөн сэргээн авч үзэхэд судалгаа шинжилгээний үнэт хэрэглэгдэхүүн болох нь гарцаагүй юм. Тухайн зурагт байлдааны сүхээр зэвсэглэсэн дайчин эр нум сум барьсан дайчинтай ойрын зайнаас тулж, бамбайгаараа сумыг халхлан сүхээ далайн зогсож байгаагаар дүрслэгдсэн нь таван талт бамбайн хамгаалалтын үүрэг тэр дундаа нум сумтны эсрэг тулаанд хэрэглэгдэж байсныг батлан харуулна. Ойрын зайн тулаанд байлдааны зээтүү, сүх, бусад зэвсгээр зэвсэглэсэн дайчинтай тулахад бамбайгаар хаан халхавчлан тулалдаж байсан нь мэдээж боловч, саваа модон сур сүвлэмэл бамбай нь голчлон нум сумтантай тулалдахад түлхүү хэрэглэгдэж байсан бололтой хэмээн үзэж байна.

Буган хөшөөн дээр сийлэгдэн, харагдах байдал нь тагнай маягийн хээтэй төстэй тул манай судлаачид тагнай хээтэй бамбай хэмээн тодорхойлон нэгэнт хэвшжээ. Археологийн биет олдвороос харахад нэгэн жигд урттай, нарийн нарийн саваа моднуудыг шир суранд зэрэгцүүлэн сүвлэн бөхөлж суулгахдаа зориуд хээлсэн мэт харагдахаар сэтгэж хийсэн байдаг нь тухайн үеийн урчуудын уран сайхны сэтгэлгээний цар хүрээг давхар илтгэн харуулж байгаа явдал юм. Энэ утгаараа нэг талаар таван талт тагнай хээт бамбай нь хамгаалах хэрэгслийн нэг төдийгүй урлаг уран сайхны бүтээл болох нь тодорхой байна.

Бамбай дүрсэлсэн буган хөшөөний холбогдох он цагийн талаар судлаачид хүрэл зэвсгийн сүүл үед хамааруулсан нэгдмэл саналтай байдаг [Эрдэнэ-Очир 2016:65; Баярсайхан, 2017:210] хэдий ч таван талт, тагнай хээн чимэглэл бүхий бамбай нүүдэлчдийн зэвсэглэлд хүрэл зэвсгийн хөгжингүй үеэс нэвтэрч эхэлсэн бололтой. Энэ санаагаа Бичигтийн амны бамбайт дайчны дүрслэлтэй холбон авч үзэж байна. Бичигтийн амны хадны зураг дотор хүрэл зэвсгийн хожуу

үеийн зургууд олон байх ба хадгалалтын байдал, зураг сийлбэрийн өнгө зэргээрээ тодорч ялгардаг. Харин бидний өгүүлэн буй бамбайт дайчны зургийн хадгалалтын байдал, зураг сийлбэрийн өнгө нь тэдгээр зургуудаас эрс ялгарна. Хадны гялтгар бор өнгөнөөс ялгарах төдий байдалтай болсон бөгөөд цоолбор гурви дээгүүр цөлийн гялтга тогтсон байна. Энэ бүхэн нь хүрлийн хожуу үеийн зургаас эрт үед зурагдсаныг илтгэн харуулна. Дээр дурдсан бүхэнтэй уялдуулан бид Бичигтийн амны бамбайт дайчны хадны зургийг хүрэл зэвсгийн хөгжингүй үеийн эхэнд холбогдуулан авч үзэх саналтай байна.

Дүгнэлт

Баянхонгор аймгийн Баянлиг сумын Бичигтийн амнаас шинээр олдсон бамбай барьсан дайчны дүрслэл бол Монголын эртний урлагийн гайхамшигт бүтээл төдийгүй Евроазийн хүрэл зэвсгийн үеийн зэр зэвсгийн судалгаанд түүхэн ач холбогдолтой дурсгал юм.

Монгол орон төдийгүй Евроазийн өндөрлөгийн хадны зургийн судалгаанд урьд өмнө таван талт, тагнай хээн чимэглэлт бамбай барьсан хүний дүрслэл хараахан олдоогүй байсан бөгөөд анх удаа олдож байгаа нь эрдэм шинжилгээний хувьд онцгой үйл явдал билээ.

Таван талт модон бамбай хүрэл зэвсгийн хөгжингүй үед үүссэнийг эртний египет, Микений грекийн соёл иргэншилд холбогдох бодит урлагийн бүтээлүүдээс харж болно. Харин Монголын хүрэл зэвсгийн хөгжингүй үеийн нүүдэлчид таван талт бамбайг өөрийн өвөрмөц арга, технологиор сэдэн хэрэглэж байсныг Бичигтийн амны хадны зураг тодоос тод гэрчлэн харуулж байна.

Буган хөшөөн дээр олонтоо сийлэгдсэн бамбайн дүрслэлийг хүрэл зэвсгийн үед хэрэглэгдэж байсан зэр зэвсгийн хамгаалалтын зориулалттай бодит хэрэгсэл байсныг батлан харуулж чадсан нь Бичигтийн амны энэ зургийн үнэ цэнийг илтгэнэ. Буган хөшөөн дээрх нууцлаг дүрслэлийг бамбай хэмээн анхлан тодорхойлсон эрдэмтдийн таамаглалыг батлан харуулснаараа тухайн дүрслэлийн түүхэн ач холбогдол оршиж байна.

Бичигтийн амны бамбайт дайчны дүрслэлийг хүрэл зэвсгийн хөгжингүй үед бид холбогдуулан үзэж байна. Үүнээс улбаалан дүгнэн үзэхэд, Монголын археологийн хосгүй, дахин давтагдашгүй дурсгал болох буган чулуун дээр дүрслэгдсэн таван талт бамбайн дүрслэл нь хүрэл зэвсгийн хөгжингүй үеийн эхэнд үүсэж түрүү төмрийн үе хүртэл хэрэглэгдэж байжээ.

Ном зүй

- Батсүх, Эрдэнэ-Очир 2017** – Батсүх Д., Эрдэнэ-Очир Н. Монгол Алтайн пазырыкийн дайчдын зэр зэвсэг. – Археологийн судлал. Том XXXVI. Fasc. 10. УБ, 2017. Тал. 139-168.
- Баярсайхан 2017** – Баярсайхан Ж. Монголын умард нутгийн буган хөшөөд. УБ, 2017.
- Вайнштейн 1974** – Вайнштейн С.И. История народного искусства Тувы. Москва, Наука, 1974.
- Волков 1981** – Волков В.В. Оленные камни Монголии. УБ, 1981
- Гантулга нар. 2018** – Гантулга Ж., Ерөөл-Эрдэнэ Ч., Магай Ж. Хөрөөгийн үзүүрийн хадны зургийн судалгаа (Хойд Тамирын хөндий дэх археологийн судалгаа). УБ, 2018.
- Гарамжав 2011** – Гарамжав Д. Хадны зурагсын уянгалаг зохиомж оршвой. УБ, 2011.
- Геродот 1972** - Геродот. История в девяти книгах. Книга IV. Л, 1972.
- Горелик 1987** – Горелик М.В. Сакский доспех – Центральная Азия. Новые памятники письменного искусства. М, 1987. 110-133 с.
- Грязнов 1950** – Грязнов М.П. Первый пазырыцкий курган. Л, 1950. 114 с.
- Деревянко и др. 2008** – Деревянко А.П., Петрин В.Т., Цэвээндорж Д., Мыльников В.П. Святилище с наскальными рисунками Баянлиг хад в Монголии. Новосибирск., 2008. 224 с.
- Древние культуры Бертекской культуры.** Новосибирск, 1994.
- Девлет 1976** – Девлет М.А. О загадочных изображениях на оленных камнях. Советская археология. №2. М, 1976. 232-235 с.
- Девлет, Девлет 2007** – Девлет М.А., Девлет Е.Г. Изображения щитов на оленных камнях – Каменная скульптура и мелкая пластика древних и средневековых народов Евразии. Барнаул., 2007. 96-99 с.
- Лукьяшко 2017** – Лукьяшко С.И. О скифских щитах. Вестник Волгоградского государственного университета. Серия 4, История. Регионоведение. Международные отношения. – 2017. – Т.22. №4. 6-16 с.
- Килуновская 1999** - Килуновская М.Е. Новый памятник наскального искусства раннескифского времени в Центральной Туве. – Проблемы развития зарубежного искусства (памяти М.В.Добровольского). Спб, 1999. 6-9 с.
- Кочеев 1998** - Кочеев В.А. К вопросу о защитном вооружении древних кочевников Горного Алтая в скифское время. – Древности Алтая, №3. Горно-Алтайск., 1998. 75-81 с.
- Кубарев 1998** – Кубарев В.Д. Курганы Уландрыка. Новосибирск., 1987.
- Монгол ба бүс нутгийн буган хөшөө. I боть.** УБ, 2021.
- Монгол ба бүс нутгийн буган хөшөө. II боть.** УБ, 2021
- Маннай-Оол 1970** - Маннай-Оол М.Х. Тува в скифское время (Уюкская культура). М, Наука, 1970.
- Манцевич 1949** - Манцевич А.П. Золотой гребень из кургана Солоха. Сокровища Эрмитажа. М-Л., 1949. 75-80 с.
- Мыц и др. 2006** – Мыц В.Л., Лысенко А.В., Шукин М.Б., Шаров О.В. Чатыр-Даг – некрополь римской эпохи в Крыму. – СПб, 2006. 208 с.
- Новгородова 1975** – Новгородова Э.А. К вопросу о древнем центральноазиатском защитном вооружении (серидина I тыс. до н.э.). – Соотношение древних культур Сибири с культурами сопредельных территорий. Новосибирск., 1975. 23-28 с.
- Новгородова 1989** – Новгородова Э.А. Древняя Монголия. М, 1989.
- Полосьмак 1992** – Полосьмак Н.В. Деревянные щиты из пазырыкских курганов. – Проблемы сохранения, использования и изучения памятников археологии. – Горно-Алтайск., 1992. 58-59 с.
- Полосьмак 1994** – Полосьмак Н.В. Стрегающие золото грифы (ак-аллахинские курганы). Новосибирск., 1994.
- Полосьмак 2001** - Полосьмак Н.В. Всадники Укока. Новосибирск, 2001.
- Руденко 1948** – Руденко С.И. Второй Пазырыкский курган. Результаты работ экспедиции Института Истории материальной культуры Академии Наук СССР в 1947 г. Предварительные сообщение. – Л.:Изд-во Гос.Эрмитаж. 1948. 64 с. XXIX табл.
- Руденко 1950** – Руденко С.И. Раскопки Пазырыкской группы курганов. – КСИИМК. Вып. XXXII, 1950. 11-25 с.
- Руденко 1960** – Руденко С.И. Культура населения Центрального Алтая в скифское время. М-Л, 1960.
- Савинов 1994** – Савинов Д.Г. Оленные камни в культуре кочевников Евразии. СПб., 1994.
- Савинов, Членова 1978** - Савинов Д.Г., Членова Н.Л. Западные передельраспространения оленных камней и вопросы их культурно-этнической принадлежности. – АЭМ. Новосибирск, 1978.
- Самашев 1992** – Самашев З.С. Наскальные изображения Верхнего Прииртышья. Алма-Ата., 1992. 288 с.
- Санжмятав 1995** – Санжмятав Т. Монголын хадны зураг. УБ, 1995.
- Синика, Тельнов 2014** – Синика В.С., Тельнов Н.П. Комплекс вооружения и предметов воинского снаряжения из скифского могильника конца IV-II вв. до н.э. у с. Глиное в Нижнем Поднепровье. – Война и военное дело в скифо-сарматском мире. Ростов-на-Дону., 2014.

- Страбон 1964** – Страбон. География. – Ленинград, 1964 (орос орчуулга)
- Сэр-Оджав 1987** – Сэр-Оджав Н. Баянлигийн хадны зураг. УБ, 1987. Тал. 161.
- Төрбат нар. 2011** – Төрбат Ц., Батсүх Д., Баярхүү Н., Жискар П.-Х. Харганатын гол ба Сыргалийн талын пазырыкийн үеийн булшууд (Судалгааны урьдчилсан үр дүн) – Археологийн судлал. Том XXX. Fasc. 7. УБ, 2011. Тал. 107-139.
- Храпунов 2010** – Храпунов И.Н. Оружие из могильника Нейзац. – Terra Barbarica. Warszawa., 2010.
- Цэвээндорж 1976** – Цэвээндорж Д. 1974 онд Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Хүнүй голд ажилласан Монгол-Унгарын экспедицийн тайлан. УБ, 1974. АХГБСХ.
- Цэвээндорж 1976** – Цэвээндорж Д. Төв Азийн эртний нүүдэлчдийн бамбай. ШУАМ. №4. 1976. Тал. 53-57.
- Цэвээндорж нар. 2016** – Цэвээндорж Д., Молодин В.И., Парцингер Г., Баярсайхан М, Лхүндэв Г. Монгол Алтайн мөнх цэвдгийн булшны судалгаа (урьдчилсан үр дүнгээс)
- Цэвээндорж нар. 2016** – Цэвээндорж Д., Молодин В.И., Парцингер Г. Монгол Алтайн пазырыкийн соёлын цэвдэгт булш. УБ, 2016. Тал. 256.
- Чугунов 2008** – Чугунов К.В. Плиты с петроглифами в комплексе кургана Аржан-2 (К хронолию аржана-маэймирского стиля). – Тропою тысячелетий: К юбилею М.А.Дэвлет. Труды Сибирской Ассоциации исследователей первобытного искусства. Вып. IV. Кемерова., 2008. Тал. 53-69.
- Эрдэнэбаатар 2002** – Эрдэнэбаатар Д. Монгол нутгийн дөрвөлжин булш, хиргисүүрийн соёл. УБ, 2002.
- Эрдэнэ-Очир, Худяков 2016** – Эрдэнэ-Очир Н., Худяков Ю.С. Монголын эртний нүүдэлчдийн зэр зэвсэг (НТӨ II мянган жил – НТӨ III зуун). УБ, 2016.
- Эрдэнэчулуун 2011** – Эрдэнэчулуун П. Тэнгэрийн илд. УБ, 2011. 495 х.
- Anati - Anati E.** Evoluzione e stile nell'arte rupestre camuna. Archivi 6, Capo di Ponte, P. 147.
- Bayarsaikhan 2005** – Bayarsaikhan J. Shamanistic Elements in Mongolian Deer Stone Art. –The Deer Stone Project Anthropological Studies in Mongolia 2002-2004. Ulaanbaatar, 2005.
- De Marinis, Fossati 2012** – De Marinis R. C., Fossati A. A. Che punto è lo studio dell'arte rupestre della Valcamonica. - Preistoria Alpina, 46 II. Museo delle Scienze, Trento 2012.
- Gui et al. 2016** – Gui U., Jie Z., Hai-Long Z., En-guo L., Dong-jun Y., Renwen Y., Jianjun B., Long W. Excavation Briefing on the Excavation of the 3rd Hua-haizi Site in Qunghe County, Xinjiang. – Outside the Xinjiang Task Force of the Institute of Archaeology, Chinese Academy of Social Sciences. Kaogu, №9, 2016. P. 985-997.